

хувьд шинэлэг заалт болон хуульчлагдсан.

Хорих байранд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг мөрдөхөөр хуульд заасан байдаг. /Хууль зүйн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/76 дугаар тушаалаар “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”/-ыг шинэчлэн баталсан.

Хууль зүйн салбарын бүтэц, тогтолцооны өөрчлөлт, эрх зүйн шинэчлэлт эрчимтэй хийгдэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалт өргөжин, боловсронгуй болохын хирээр цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх ойлголт, улам баяжиж, олон хүчин зүйлээс хамааран хэрэгждэг хүний эрхийн томоохон болоод эмзэг, нарийн ойлголт болон хөгжсөөр байна.



О.БАЯРЖАРГАЛ

Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн сургуулийн
Нийгмийн ажлын
тэнхимийн багш, ахлах
дэслэгч, магистр

ШИНЭЭР ИРСЭН ЯЛТАНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Системийн онолын үнэ цэнэ нь бусад онолууд шиг хүний болон нийгмийн зан үйлийн нэг хэсгийг биш бүхлээр нь авч үздэгт оршино (Хансон, 1995 он). Энэхүү онолыг Ф.Бертиланфи 1971 онд ерөнхий системийн онолоос нийгмийн ажлын системийн үзэл баримтлалыг гаргаж иржээ. Хүний хэрэгцээний асуудлыг томоохон систем тогтолцооноос ангид авч үзэж болохгүй юм гэж үзсэн.

Тус онол нь нийгмийн ажилтны анхаарлыг биологи, нийгмийн олон системийн хоорондын харилцан үйлдэлд хандуулж, энэ харилцан үйлдэл нь үйлчлүүлэгчийн зан үйл, үйлдэлд нөлөөлнө гэж үздэг. Хорих байгууллагад байгаа ялтны асуудал ч тэдний орчин дахь харилцан үйлдлээс хамаарч зан үйл, үйлдэлд нь нөлөөлдөг болох нь тодорхойлогдсон.

Системийн хандлага нь хүн түүний хүрээлэн байгаа нийгмийн орчин хоорондын харилцаа хамаарлыг ойлгоход тусалдаг бөгөөд түүний тэнцвэрт байдлыг хэрхэн хадгалах хэрэгтэй вэ, энэ нь хир ач холбогдолтой вэ гэдгийг ойлгуулдаг. Хорих ангид шинээр ирсэн ялтануудын хувьд хуучин хоригдлууд бүхий шинэ орчинд дасан зохицох хэрэгцээтэй болдог бөгөөд тэдний дунд тэнцвэрээ хадгалан барих нь тэвчээр шаардсан мэргэжлийн

туслалцаатай хийгдэх үйл ажиллагаа юм.⁶⁷

Нийгмийн ажлын системийн хандлагаар үйлчлүүлэгч, түүний нийгмийн орчны харилцааг дэмжих нь үйлчлүүлэгчийн сайн сайхан байхын баталгааг хангаж чадна гэж үздэг. Юуны өмнө хорих анги дахь шинээр ирсэн ялтны дасан зохицох үйл явцад нийгмийн ажилтан анхаарч ажиллах хэрэгтэй. Ингэхдээ хорих ангийн нийгмийн ажилтнууд дотоод дэг, журмыг танилцуулах мэдээлэл өгөхөөс гадна, хуучин хоригдол, өрөөний ялтнуудтайгаа хэрхэн анхны харилцаагаа үүсгэх, ямар нэг дарамт, шахалтанд орвол хэрхэн өөрийгөө хамгаалах, жам ёсны эрхээ эдлэх тухай гэх мэт нийгмийн, харилцааны, дасан зохицоход шаардагдах зарим ур чадварыг суулгахад анхаарах нь зүйтэй.

Энэ хандлага нь нийгмийн ажлын үйлчилгээний эхний үе шатнаас эхлэн хэрэгжих бөгөөд ялангуяа нөхцөл байдлын үнэлгээнд түлхүү хэрэглэгддэг. Ингэхдээ нийгмийн нэг систем нөгөөтэйгээ харилцан хамааралд орших тул нэг системд гарсан өөрчлөлт нөгөөд нь нөлөөлнө гэх үзлийг баримтална. Нийгмийн системийн онол нь нийгмийн ажлын мэргэжлийн зарим үйлчилгээ, үйл ажиллагаанд тодорхой тусгалаа олсон. Тухайлбал:

- Хувь хүнтэй ажиллах нийгмийн ажил
- Олон нийтийг зохион байгуулах
- Бүлэгтэй ажиллаж, хувь хүний түвшинд өөрчлөлт хийх
- Нийгмийн өөрчлөлт гэх мэт зайлшгүй үйлчилгээнд хэрэглэгдэж байна. Энэ тохиолдолд хувь хүний түвшинд өөрчлөлт хийх нь шинээр ирсэн

ялтныг одоо байгаа орчинд дасгах, орчныг нь хүлээн зөвшөөрүүлэх талаарх арга хэмжээ юм.

Системийн онолын үндсэн ойлголтуудыг авч үзвэл, систем бүр хил хязгаартай байх бөгөөд энэ хилээс дотогш байгаа энергийн солилцоо нь хил хязгаараас гадагш харьцах энергийн солилцооноос маш хүчтэй байна. Жишээ нь хорих ангид шинээр ирсэн ялтнууд бол хил хязгаараас дотогш бүс гэж тооцвол тэдгээрийн гадагшаа чиглэлтэй харилцаанаас илүүтэй тэд өөрсдөө өөрийнхөө асуудлыг хэрхэн даван туулж байгаа нь чухал юм.

Хаалттай систем нь гаднах орчинтойгоо ямар нэг зүйл солилцдоггүй. Ихэнх шинээр ирсэн хоригдогчид хямралын байдалтай, хийсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрдөггүй байдлыг энэ системд хамруулж болох юм. Гадагшаа чиглэлтэй харилцаа байхгүй ч дотооддоо зөрчилтэй байгаа хоригдогч өөрөө хаалттай системд тооцогдоно.

Нээлттэй систем нь хил хязгаараараа энергийг чөлөөтэй солилцоно. Зарим үйлчлүүлэгчийн зан байдлаас болоод дээрх хаалттай систем үүсдэг ч харьцангуй сэтгэлийн тэнхээтэй, болж буй үйл явцаа хүлээн зөвшөөрсөн хоригдогчийн хувьд хил хязгаарлуугаа гадны энерги буюу тодорхой үг, үйлдэл, тохиолдлыг нэвтрүүлэх боломжтой байна. Энэ нь нэг талаас ямарваа нэг үйлчилгээ авч, түүний үр дүн гарах эерэг боломжтойг илэрхийлж байгаа ч нөгөө талаас сөрөг ч энерги нэвтрэх магадлалтай юм.

Эдгээрээс гадна систем хэрхэн ажилладаг, түүнийг хэрхэн өөрчилж болдог талаарх ойлголт байдаг.

Орц гэдэг нь системийн хил хязгаараар дамжин гаднаас орж ирэх энерги буюу хорих байгууллага дахь нийгмийн

⁶⁷ Каритас Чех байгууллага “Хувь хүнтэй ажиллах нийгмийн ажил” УБ 2010 он

ажилтны үйлчилгээ, бусад хоригдогчийн нөлөөлөл, сөрөг ч агуулгатай үйл ажиллагаа байж болно. Гэсэн хэдий ч хоригдол л түүнд хэрхэн хандаж, хүлээж авах нь орцын үүргийг тодорхойлох юм. Орц нь өөрийн гэсэн шинжээ хадгалсаар байдгийг санах хэрэгтэй.

Үйл ажиллагааны механизм нь гаднаас авсан энергийг систем хэрхэн ашиглаж байгааг хэлнэ. Жишээ нь нийгмийн ажилтны өгсөн үүрэг даалгавар байвал ялтан өөрөө дээрээ хэрхэн гүйцэтгэж байгаа талаар байж болно.

Эргэх холбоо нь системийн гаднаас энерги авахгүй бол өөрийнхөө дотоод энергийг хэрэглэж дуусна гэсэн үг юм. Тухайлбал ялтан нь өөрийнхөө бүх нөөц боломжоор шинээр ирсний дараах асуудлаа шийдвэрлэсэн бол энэ ангилалд орж болно гэсэн үг юм.⁶⁸

Системийг үнэлэх 5 шинж

1. Тогтвортой байдал
2. Тэнцвэртэй байдал
3. Төрөлжих чадвар
4. Цуглуулга биш байх
5. Харилцан уялдаатай байдал

Үйлчлүүлэгчийн асуудал бэрхшээлийг хүн ба түүний орчин, нийгмийн харилцаа хамаарлыг бүхэлд нь авч үздэг онол учраас хорих анги болон түүний орчин, шинээр ирсэн ялтнуудад үйлчилгээ хүргэхэд энэ хандлага үр дүнтэй юм.

Хорих ангид шинээр ирсэн ялтанд үйлчилгээ үзүүлэхэд хүрээлэн буй орчны холбоо хамаарлыг харгалзан тэрхүү орчинд байгаа нөөц бололцоог ашиглан үйлчилгээг үзүүлнэ. Нийгмийн ажилтан хэрэгцээнд суурилсан үйлчилгээ хүргэхэд ганц шинэ ирсэн ялтныг бус хорих байгууллага, бусад ялтан тэдний ар гэр, хамаатан садан, найз нөхөд, хамт олон, үйлчилгээ хүргэдэг төрийн болон төрийн

бус байгууллага хоорондын нарийн холбоо хамаарлыг авч үзнэ. Эрдэмтэн Пинкус ба Минахан нар нийгмийн ажилд системийн үзэл баримтлалыг хэрэглэсэн байдаг.

1. Албан бус буюу натурал системд бусад ялтнууд, гэр бүл, хамаатан садан, найз нөхөд, хамт олон
2. Албан ёсны системд хорих анги, албан хаагчид, төрийн байгууллага
3. Нийгмийн системд хорих ангийн болон бусад эмнэлэг, төрийн бус байгууллага

Систем бол ямар ч холбоо хамааралгүй шинж бүхий зүйлсийн нэгдэл бус ертөнцийн бүх зүйл харилцан хамааралтайг харуулсан онолын гаргалгаа бөгөөд шинээр ирсэн ялтнуудын хувьд нийгмийн ажилтан системийн онолыг ашиглан нөхцөл байдлын үнэлгээ хийн одоогийн түвшинг тодорхойлох, тэдгээрт энэ хандлагын дагуу үйлчилгээ хүргэх нь зүйтэй юм.

Түүхэн хугацааны туршид гяндан, шорон, колони, хорих анги хэмээн нэрлэгдэж ирсэн байгууллагад ялаа эдэлж байгаа хоригдогчдыг хүмүүжил, сургалтын ажилд хамруулан тэдэнд аятай нөлөө үзүүлэн чөлөөт амьдралд бэлтгэж ирсэн. Энэ ч утгаараа хорих байгууллагын нийгмийн ажил цаг үеэ даган хэрэгцээ шаардлага нь өсөн нэмэгдсээр байна. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн дараах баримт бичгүүд байдаг. Үүнд: Хорих ангийн дотоод журам, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлын заавар, Ялтныг нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр. Эдгээр хууль эрх зүйн баримт бичгүүдэд хорих ангид шинээр ирсэн ялтнуудад үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний талаар хэрхэн тусгасныг үзвэл.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт”-д шинээр ирсэн ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой асуудлыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

Ялтан, хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагааг хүргэхэд оршино.

- Ялтан, хоригдогч нэг бүрийн хэрэгцээ, хувь хүний эерэг болон сул тал, харилцаан дахь бэрхшээлийг илрүүлж, үнэлгээ өгч ганцаарчилсан болон бүлгээр ажиллах чиглэлийг тодорхойлох

- Ялтан, хоригдогчийн зан төлөв, сэтгэл зүйн хандлагыг судалж, бодитоор тогтоох зорилгоор хорих ангийн сэтгэл зүйчтэй хамтран судалгааны ажлыг тогтмол явуулах

- Нийгмийн ажлын судалгааг ажиглалтын, шат дараалсан ярилцлага явуулах, хувийн баримт мэдээлэлд дүгнэлт хийх болон шинжлэх ухааны бусад аргыг ашиглан явуулах

- Анх удаа болон шинээр ирсэн ялтан, хоригдогчдын дундаас орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэлзүйн гүнзгий хямрал, өөрчлөлтөд орсон ялтан, хоригдогчтой ганцаарчлан ажиллаж, эрх зүйн болон нийгмийн ажлын зөвлөгөө туслалцааг үзүүлэх

- Ялтан, хоригдогчийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх зүйн орчин болон амьдрах нөхцлийн талаар таниулан ойлгуулах уулзалт, ярилцлага, бусад арга хэмжээг зохион байгуулах

- Ялтан, хоригдогчийг эрх зүй, танин мэдэхүйн, чиглэлээр гарын авлага, зөвлөмжөөр хангаж, зан байдлын сөрөг өөрчлөлтөнд орохоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

- Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх, нөлөөллийн болон сэтгэл заслын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн тушаалаар баталсан “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлын заавар”-т шинээр ирсэн ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой асуудлыг дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэрээр хүргэгдэн ирсэн хоригдогчийг хүлээн авсны дараа 7 хоногийн хугацаанд хоригдогчийн хувийн хэрэг, иргэний бичиг баримт болон доорх бусад мэдээллийг цуглуулна.

- Зан төлөв

- Биеэ авч яваа байдал

- Хувийн сэтгэл зүйн онцлог

- Орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл санааны хямралд орсон эсэх

- Хувь хүний давуу талууд буюу мэргэжил, боловсрол, спорт, урлагын болон бусад авьяас чадвар боломжууд

- Ар гэр, төрөл төрөгсөд, найз нөхөд буюу ойр дотны хүмүүсийн талаар

- Ажиллаж амьдарч байсан газар, нутаг орон

- Урьд нь ял шийтгэл эдлэж байсан тохиолдолд тухайн үеийн ял эдлэлтийн байдал

- Үйлдсэн гэмт хэргийн байдал

- Сэтгэцийн эрүүл мэндийн байдал - Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь дээрх чиглэлээр судалгаа хийхдээ ажиглалт хийх, шат дараалсан ярилцлага явуулах, хувийн баримт бичигт дүгнэлт хийх болон бусад аргыг ашиглана. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь

хийгдсэн судалгаанд үндэслэн дараах шийдвэрийг гаргана.

- Цаашид нийгэмшүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулахаа тодорхойлох
- Тухайн хоригдогчтой ажиллах арга, аргачлалаа тогтоох
- Байгууллагын зүгээс хоригдогчийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд зөвлөмж өгөх

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь хоригдогчийн нийгэм сэтгэл зүйн байдал, зан байдлын онцлог, төлөвшлийг тодорхойлох судалгааг явуулахдаа дангаар эсхүл хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны бусад албад болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран явуулна. Анх удаа болон шинээр ирсэн хоригдогчийн дундаас орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл зүйн гүнзгий хямрал, өөрчлөлтөд орсон хоригдогчтой ганцаарчлан ажиллаж, эрх зүйн болон нийгмийн ажлын зөвлөгөө тусалцааг үзүүлнэ.

3. Монгол улсын хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/230 тоот тушаалаар шинэчлэн баталсан Хорих ангийн дотоод журам-д шинээр ирсэн ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой асуудлыг дараах байдлаар тусгасан.

- *Ялтныг хүлээн авах:* Ялтан ял эдлэхээр хуваарилагдан ирсэн тохиолдолд дараах бүрэлдэхүүнтэй комисс хүлээн авна.

1. Гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга
2. Төлөөлөгч
3. Нийгмийн ажилтан
4. Тоо бүртгэлийн ажилтан
5. Эмч
6. Ерөнхий жижүүр /ээлжийн дарга/

Шинээр хүлээн авсан ялтныг 14 хүртэл хоног тусгаарлан байрлуулж, ангийн дотоод журамтай танилцуулан зохих сургалтад хамруулах ба энэ хугацаанд

нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар дараах ажлыг зохион байгуулна:

- тухайн ангийн хориотой бүс, ялтны эрх, үүргийн талаар танилцуулах;
- биечлэн уулзаж зан байдлыг тодорхойлж, сэтгэл зүйн оношлогоо хийх
- ялтны боловсролын түвшин, мэргэжил, хөдөлмөрийн дадлага, чадварыг тогтоох;
- ялтныг байрлуулах, хөдөлмөрлөх хуваарь гаргах;
- ялтныг нэг загварын гадуур хувцас, гутлаар хангах;
- хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;
- ялтан тухайн ангид ял эдлэхээр ирсэн талаар түүний ар гэрт нь нэн даруй мэдэгдэж, хорих ангийн байршил, эргэлтийн хуваарь, хориглох эд зүйлсийг нийгмийн ажилтан танилцуулах;
- хорих ангид оруулахыг хориглосон эд зүйлс, хувцсыг буцаах буюу тусгай зориулалтын өрөөнд хадгалах;
- ялтны мөнгө, үнэт эдлэл, үнэт цаас зэргийг хорих ангийн санхүүд шилжүүлэн нэрийн данс нээж хадгалуулна. Ялтан банкинд харилцах данстай байгаа бол түүний талаарх мэдээллийг нийгмийн ажилтан ар гэрийнхэнд нь мэдэгдэж мөнгөн гуйвуулгын талаарх мэдээллийг хүргүүлнэ.
- Сургалтад хамрагдсан ялтныг нийгмийн ажилтны саналыг үндэслэн ангийн даргын баталсан хуваарийн дагуу өрөөнд байрлуулна.

Хорих ангийн нийгмийн ажилтнуудын хувьд шинээр ирсэн ялтанг хүлээж авахад оролцох ба эхний долоо хоногт багтаан хорих ангийн дүрэм журам, ялтны эрх үүргийн талаар мэдээлэл өгөх, ар гэртэй нь холбоо бариулж, утсаар яриулахад голлон анхаарч ажиллаж байна. Харин эдгээрээс гадна хоригдогчдод нэн тэргүүний шаардлагатай байгаа тусламж дэмжлэг